

ЭМГ-ын 7 хоногийн мэдээ

Зарим статистик үзүүлэлтүүд

- Нийт төрөлт 54
- Амьд төрөлт 55
- Амьгүй төрөлт 0
- Дутуу төрөлт 2
- Нялхсын эндэгдэл 0
- 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1
- Эхийн ноцтой хүндрэл 0
- Төрөлхийн гажиг 0
- Гэрийн төрөлт 0

Халдварт өвчний чиглэлээр :

- Томуугийн эсрэг вакцины сайн дурын дархлаажуулалтын үйл ажиллагааг зохион байгуулж байна. 2017 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Сайн дурын дархлаажуулалт ЭМГ-т дархлаажуулалтын кабинетэд хийгдэж байгаа ба нийтдээ 20 хүүхдийг хамруулсан.

- Хилийн цэргийн 0165 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагч нарыг Тэмбүү, ХДХВ-ийн халдвар илрүүлэх урьдчилан сэргийлэх шинжилгээнд 50 хугацаат цэргийн албан хаагчийг хамруулсан.

- Ногооннуур сум дундын эмнэлэгт энэ долоо хоногийн байдлаар 2 хүүхэд нэмэгдэж эмнэлэгт хэвтэн эмчлэгдэж байна. Голомтонд тандалт судалгаа болон бусад хариу арга хэмжээг авч мэргэжлийн арга зүйгээр ханган ажилласан.

- Харьяа эрүүл мэндийн байгууллагуудад салхинцэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх гарсан үед авах арга хэмжээний талаар зөвлөмж хүргүүлсэн.

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр:

- Үр хөндөлт ,охидын эрүүл мэнд , томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлгийг 1 удаагийн давтамжтай 2 удаагийн зөвлөгөө ярилцлага өгсөн.

- Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасагт дэмжлэгт үнэлгээ хийгдсэн болон Томуу томуу төст өвчнөөс сэргийлэх МСС-ны төлөвлөгөөний дагуу хийсэн үйл ажиллагаануудыг ЭМГ-ын вэб сайтад байршуулсан .

Сургалт сурталчилгааны чиглэлээр :

ЭМГ-ын даргаар батлуулан томуу, томуу төст өвчний эрсдэлээс сэргийлэх мэдээлэл сурталчилгааны төлөвлөгөө гарган энэ долоо хоногт 11 цэцэрлэгүүдэд хүүхдүүдийн ирцийн бүртгэлийн тандалт судалгаа хийж, Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлье, томуугийн цэгэн массаж, Салхинцэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх сэдэвт сургалтыг нийт 130 ажилчдад явуулсан.

ЭМГ-ын нийт ажилчдад “Томуугийн харуулдан тандалт, БЗДХ, ХДХВ, ДОХ-ын тусламж үйлчилгээ үзүүлэх журмын талаар дотоод сургалт хийсэн.

Олон нийтийн үйл ажиллагааны чиглэлээр :

Аймгийн Засаг даргын № А/447 дугаар захирамжийн дагуу “ Хөх сав, канестергүй аймаг, сум, баг хөдөлгөөн өрнүүлэх” сэдвээр сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн хийсэн ажлуудын тайланг нэгтгэж байгаа ба тайлангаа 11 сарын 20-нд ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэст хүргүүлэхээр төлөвлөж байна.

Мэргэжлийн Хяналтын Ерөнхий газраас зохион байгуулсан “Иргэн бүр эрсдэлтэй орчинд” сарын аян болон Өлгий сумын хэмжээнд “Цэвэрч, соёлтой хот” аяны хүрээнд хийсэн их цэвэрлэгээний ажилд хамт олноороо идэвхтэй оролцон тайлангаа Өлгий сумын Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн .

Хяналт үнэлгээний чиглэлээр :

- Аймгийн Засаг даргын тамгын газарын хяналт-шинжилгээ, үнэлгээний тасгийн ажлын хэсэгтэй хамтран Алтай , Буянт сумдын эрүүл мэндийн байгууллагуудад хяналт үнэлгээ хийж, зөвлөмж хүргүүлэн ажиллаж байна.
- Харьяа сумын эрүүл мэндийн төвүүдтэй жирэмсэн эмэгтэйчүүдийн товлолын дагуу БЗДХ илрүүлэх шинжилгээнд хамрагдалтын байдал болон ХДХВ/ДОХ, тэмбүүгийн оношлуурын нөөц, бэлэн байдалд хяналт хийсэн.

- ЭМС-ын БЗДХ-ын тусламж үйлчилгээний журам батлах тухай 305-р тушаалын хэрэгжилтийн талаар сумын эрүүл мэндийн төвүүдэд зөвлөгөө өгсөн.
- Нэгдсэн эмнэлэгийн хүүхдийн тасагт Томуу томуу төст өвчний бэлэн байдалд дэмжлэгт үнэлгээ хийсэн.

ЭТХэлтэсээс санаачлан нэгдсэн эмнэлгийн сувилахуйн тусламж үйлчилгээг сайжруулах зорилгоор АНЭ, ӨЭМТөвүүдийн ахлах сувилагч нарын хэлэлцүүлгийг зохион байгуулж сувилахуйн тусламж үйлчилгээний өнөөгийн байдлыг хэлэлцэж цаашид хийх ажлын төлөвлөгөөний төслийг гаргалаа. Хэлэлцүүлэгт нэгдсэн 14, өрхийн эрүүл мэндийн төвийн 4 ахлах сувилагч, ЭТХ-ийн 4 мэргэжилтэн оролцлоо.

Өрхийн эрүүл мэндийн төвүүд, Толбо, Бугат сумын эрүүл мэндийн төвүүд, аймгийн нэгдсэн эмнэлгийн хүүхдийн амбулаторт Хүүхдийн өвчний цогц менежментийн орчны үнэлгээ хийв.

Хүн амын бие бялдрын хөгжилт, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил, 0-5 насны хүүхдийн өсөлтийг хэмжих аргачлалын талаарх сургалтыг аймгийн төвийн 18 цэцэрлэгийн 23 багш, эмч нарт явуулав. Уг сургалтыг хүүхдийн эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн, НБТЧ-ийн арга зүйч нар заасан.